

нийгмийн хүчийг нэг зорилгод төвлөрүүлэх, Монгол улсаа дэлхийд таниулан Чингисийн Монгол гэдэг орчин үеийн хүчирхэг брэндийг бүтээхэд макромаркетингийн сонгодог стратегиудыг хэрэглэх нь үлэмж чухал болоод байна. Энд хэсэгчлэх, сонгох, хоногшуулах, ялгавар гаргах, брэнд бүтээх стратегиуд хамаарагдаж байна.

7. Монгол төрийн удирдлага, хөгжлийн бодлогыг маркетингийн үзэл баримтлалын үүднээс шинжлэн судалж цаашдын арга замыг тодорхойлох нь Монгол Улсын тулхтай хөгжлийн нэгэн чухал үндэс мөн.

Цаашид төрийн бодлого, удирдлагын үйл ажиллагааны түвшинд макро маркетингийн үзэл баримтлалын үүднээс цаг хугацааны хувилбартайгаар үнэлгээ хийж засаглалын үр ашгийг сайжруулахад тусгаж байх нь ихээхэн ач холбогдолтой байх болно.

Ашигласан материал:

1. Philip Kotler, Somkid Jarusripittak, Suvit Maesincee The nation's marketing
2. Д. Дагвадорж, Г.Мөнхбаясгалан, Н.Отгонсайхан. Төрийн удирдлагын асуудлын макромаркетингийн шинжилгээ. "Төрийн удирдлага ба маркетинг" онол-практикийн бага хуралд тавьсан илтгэл. УБ. 2007.
3. Д.Дагвадорж Маркетинг зах зээлд хөтлөх түлхүүр ухаан УБ хот 2000 он
4. Д.Дагвадорж Монголын маркетингийн менежмент. УБ хот 1998 он
5. Ж. Энхбаяр Эдийн засгийн аюулгүй байдал ба батлан хамгаалах салбарын зарим тулгамдсан асуудал, 2007 он
6. Хүний хөгжлийн тайлан илтгэл 2006
7. Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан 2006
8. Үндэсний статистикийн газар Статистикийн эмхэтгэл 2005, 2006 он
9. GDP (nominal) per capita for the year 2006. Source: IMF (April 2007)

3

ХӨДӨӨ АЖ АХУЙН ӨРХҮҮДИЙН ҮЙЛ ХӨДЛӨЛИЙГ ЗАГВАРЧИЛАХ НЬ

Х.Цэвэлмаа

Хөдөө аж ахуйн өрхүүдийн үйл хөдлөлийг загварчилах онолын үндэслэл

Зах зээлийн харилцаанд оролцогч гол субъектүүдийн талаарх шинэ сонгодог онол, загваруудыг хөгжлийн бодлогын тоон шинжилгээнд өргөн хэрэглэж байна.

Хөгжлийн бодлогын тоон шинжилгээнд зах зээлийн харилцаанд оролцож буй субъектүүдийг логик үндэслэлтэй судалж, загвар ашиглан үйл хөдлөлийг нь тайлбарласнаар нийгмийн олон асуудлыг ялгаатай бодлогоор зохицуулах боломжтой гэж үздэг. Үүний нэг жишээ бол зах зээлийн харилцааны гол субъект болох өрхүүдийн үйл хөдлөлийг, тэр тусмаа хөдөө аж ахуйн өрхүүдийн үйл хөдлөлийг нарийвчлан тодорхойлох явдал юм. Шинэ сонгодог экономикст өрхүүдийн үйл хөдлөлийг судлахдаа төсвийн хязгаарлалттайгаар ханамжийг хамгийн их байлгах функцийг ашиглан шинжилдэг. Гэхдээ өрхүүдийн үйл хөдлөл нь рациональ учраас зах зээл төгс байхад өрхүүд оновчтой сонголт хийж, улмаар өрхүүдийн нийт эрэлтийг тодорхойлсноор хэрэглэгчийн илүүдлийг нарийвчлан хэмжинэ. Гэтэл бодит байдалд өрхүүд аливаа үйлдлийг хийхэд ямагт нэмэлт зардал гаргаж, онолын таамаглалд үндэслэн судлахад бэрхшээлтэй байхын сацуу аливаа үйлдэл бүхэн алдагдсан боломжийн зардал өндөртэй байгаа тул зах зээлийн гажуудлыг хамтатган авч үзсэнээр өрхүүдийн үйл хөдлөлийг судална.

Хөгжиж буй орнуудын хүн амын 70-аас илүү хувь нь хөдөө аж ахуйн фермер (тариачин) өрхөд хамрагдаж байна. (Хүний хөгжлийн илтгэл, 2007) Хөдөө аж ахуйн тариачин өрхүүдийн үйл хөдлөл микроэкономикст тайлбарлаж буй өрхүүдийн үйл хөдлөлөөс арай ялгаатай. Тиймээс хөгжлийн эдийн засагчид

өрхүүдийн загварыг микроэкономиксийн загваруудад үндэслэн боловсруулж, хөгжлийн бодлогын тоон шинжилгээнд ашиглаж байгаа юм.

Хөдөө аж ахуйд ажиллаж буй өрхүүд яагаад эдийн засгийн судалгаанд чухал ач холбогдолтой байна вэ? Юуны түрүүнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэмжээ нь тэнд ажиллаж буй хүмүүсээс шууд хамааралтай. Цаашилбал, хөдөө орон нутагт ядуу хүмүүс олон байгаа болохоор дэлхийн төдийгүй бүс нутгийн ядуурал, тухайн улс орны ядуурлын хэмжээнд нөлөөлж байна.

Хөдөө аж ахуйн өрхүүдийг онцолж авч үзэж байгаагийн өөр нэг шалтгаан нь өрхүүд хугацааны туршид *үйлдвэрлэл, хэрэглээ, хийж гүйцэтгэх ажлынхаа талаар шийдвэр гаргаж байдаг нэг чухал институци* юм. Үүний зэрэгцээ өөр бусад зах зээлүүд хөгжсөөр байхад хөдөө аж ахуйн өрхүүд *хагас наймааны хэлбэртэй аж ахуйтай хэвээр байна* гэж үзэж болно. Яагаад гэвэл, хөдөө аж ахуйн өрхүүд ядаж л өөрсдийн хэрэглээг өөрсдөө хангана, хөдөлмөрийн нөөцийн зарим хэсэг, тухайлбал, гэрийн эзэгтэйн хөдөлмөр өрхийн үйлдвэрлэлд шууд оролцоно. Хэрэглээний зарим хэсгийг хязгаарлаж, барааны зах зээлд нийлүүлж болно. Хэрвээ гэрт байгаа ажиллагсдын тоо хангалттай гэж үзвэл орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн үйл ажиллагаанд оролцож болно. Хэрвээ үйлдвэрлэл хэрэглээнээсээ бага хийгээд ажиллагсдын тоо хүрэлцэхгүй гэж үзвэл хөдөө аж ахуйн өрхүүд шинээр бараа худалдан авагч, мөн шинээр ажил хайгч болно. (Элизабет Садоулет, Алаин Жанври, 1995)

Өөр бас нэг шалтгаан бол хөдөө аж ахуйн зах зээлд мэдээлэл хангалтгүй, өрсөлдөөн бага, гэрээг албадан хэрэгжүүлэх үйл явц сул байгаа учраас хөдөө орон нутагт амьдарч, ажиллаж буй өрхүүдийн трансакцийн зардлыг бууруулж, хөдөө аж ахуйн зах зээлийн үйл ажиллагааг сайжруулахын тулд *институцийг* бий болгох хэрэгтэй байна. “Дэлхийн хөгжлийн илтгэл 2002”-д үзүүлснээр бодлого боловсруулагчид хөдөө аж ахуйн зах зээлд институцийг бий болгохдоо газарзүйн ялгаа, хөдөө рүү чиглүүлж байгаа нийгмийн барааны асуудал, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цаг агаараас хараат байгаа явдлыг зайлшгүй анхаарах нь чухал. Иймд хөдөө аж ахуйн маркетинг, зээлийн институци, газрын зах зээл: газрын түрээс, газрын бүртгэл, газрын зураглал гэх зэрэг асуудлыг шат дараалалтай шийдвэл хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд гэрээ, хамтын нөхөрлөл, хоршоо, зах зээлийн мэдээллийн систем хөгжихийн зэрэгцээ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний стандарт сайжирч, хөдөө аж ахуйд ажиллагсдын хөдөлмөрийн бүтээмж дээшлэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн технологи эрс шинэчлэгдэх нөхцөл бүрдэх болно. Мөн түүнчлэн бичил зээлийн үйлчилгээ хөдөөгийн өрхүүдийн үйлдвэрлэлд зохих хувь нэмэр оруулж байгаа үйл явцыг өргөжүүлэхийн зэрэгцээ шинэ шинэ зээлийн үйлчилгээг бий болгох явдал чухал нөлөө үзүүлэх болно. Тэр тусмаа дэд бүтэц сайтар хөгжөөгүй, төвөөс алслагдмал газар амьдарч байгаа өрхүүдэд санхүүгийн үйлчилгээг ойртуулахад тус дөхөмтэй байх болно.

Газрын зах зээлийн үйл ажиллагааг аль болох хурдан эхлүүлбэл хөдөөгийн өрхүүдийн үл хөдлөх хөрөнгийн талаарх сэтгэлгээ өөрчлөгдөж, газар өмчлөл, эзэмшил, ашиглалт нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, институцийн орчны зохицуулалтын дор хөгжих болно.

Хөдөө аж ахуйн өрхүүдийн үйлдвэрлэлийн талаарх загвар Чаяановын¹ (1920) ажлаас эхлэлтэй бөгөөд өрхүүд хөдөлмөрийн зах зээлд оролцохгүйгээр газрыг чөлөөтэй ашигладаг гэж үзсэн. Үүний дараа Бекер (1965) өрхийн экономикст² өрхүүдийн ханамж нь худалдан авч буй бараанаас шууд бий болохгүй, өрхийн хөдөлмөр алдагдсан боломжийн өртөгтэй гэж үзэн өрхүүдийн цаг хугацаагаа хэрхэн хуваарилж болох үйл явцыг авч үзсэн. Цаашилбал, Харрисон³ (1975) амьдралын туршид ажлын оптимум хүчин чармайлт өөрчлөгддөг гэдгээс хүн ам зүйн ялгаатай байдлын үзэл баримтлалыг дэвшүүлсэн. Хөдөө аж ахуйн өрхүүдийн бүрэн загварыг Барнум болон Скуайр нарыг (1979) боловсруулсан гэж үздэг.⁴ 1986 онд Сингх, Скуайр, Страусс⁵ нар боловсронгуй болгожээ.

Эдгээр онолын загваруудад үндэслэн хөдөө аж ахуйн өрхүүдийн үйл хөдлөлийг шинжилж, эмпирик үнэлгээг хийж байна.

Хөдөө аж ахуйн өрхүүдийн үйл хөдлөлийн загвар

Хөдөө аж ахуйн өрхүүдийн үйл хөдлөлийг загварчилахдаа микроэкономикст авч үздэг загваруудад үндэслэнэ. Микроэкономикст пүүсүүдийн ашиг хамгийн их байх болон өрхүүдийн ханамж хамгийн их байх нөхцөл, хөдөлмөрийн чөлөөт ба ажлын цагийн оновчтой сонголт гэх зэрэг нь салангид тодорхойлогддог. Эдийн засгийн онолд үйлдвэрлэл, хэрэглээ, хөдөлмөрийн шийдвэрийг салангид шинжилж, гурван ялгаатай агентын үйл хөдлөлөөр тайлбарладаг.

Эхлээд үйлдвэрлэлийг товч дүрслэе. Үйлдвэрлэгчид нэг төрлийн бүтээгдэхүүн (q_a) үйлдвэрлэж, зах зээлийн үнээр (p_a) нийлүүлнэ; хоёр төрлийн хүчин зүйлийг (x, l) ашиглаж, төлбөр (p_x, w) хийнэ; фермер тогтмол

¹ A.V.Chayanov, "Report of the Congress of Agronomists advising the public" (1911), "On the problem of training agricultural officers" (1914), "Fundamental ideas and working methods in Social Agronomy", (1918)

² □New home economics□ Becker, Gary. 1965. □A Theory of the Allocation of Time□. Economic Journal 75: 493-517

³ Harrison, Mark. 1975. □Chayanov and the Economics of the Russian peasantry□. Journal of Peasant Studies 2: 389-417

⁴ Barnum Howard, Lyn Squire. 1979. A Model of an Agricultural Household: Theory and Evidence. Occasional Paper no.27, Washington, D.C.: World Bank

⁵ Singh, Inderjit, Lyn Squire and John Strauss eds. 1986. Agricultural Household Models. Baltimore Johns Hopkins University Press

орц z^q ашиглана гэж таамаглах бөгөөд үйлдвэрлэгчийн ашиг дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

$Max_{q_a, x, l} \pi = p_a q_a - p_x x - w l$ ашгийн функцийг $g(q_a, x, l, z^q)$ гэсэн үйлдвэрлэлийн функцийн хязгаарлалттайгаар хамгийн их байлгах асуудлыг шийдэх юм. Хураангуйлбал:

- нийлүүлэлтийн функц: $q_a = q(p_a, p_x, w, z^q)$,
- хүчин зүйлийн эрэлтийн функц: $x = x(p_a, p_x, w, z^q)$,
 $l = l(p_a, p_x, w, z^q)$,
- максимум ашиг: $\pi = \pi(p_a, p_x, w, z^q)$ болно.

Дараагийн асуудал нь хэрэглээ болно. Хэрэглэгчид хоёр төрлийн бүтээгдэхүүнийг, тухайлбал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн c_a (p_a үнэтэй) ба аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг c_m (p_m үнэтэй) хэрэглэнэ. Хэрэглэгч зарцуулах орлоготой у, зах зээл дээр z^c хэрэглэгч байгаа.

$Max_{c_a, c_m} u(c_a, c_m, z^c)$ ханамжийн функцийг $p_a c_a + p_m c_m = y$ гэсэн төсвийн хязгаарлалттайгаар хамгийн их болгох юм. Хураангуйлбал:

- эрэлтийн функц: $c_i = c_i(p_a, p_m, y; z^c)$, $i = a, m$.

Сүүлийнх нь хөдөлмөр хэмээх хувьсах орц бөгөөд үнэн хэрэгтээ ажилчин хөдөлмөрөө үнэлүүлэхээр сонголт хийх үйл явц болно. Хөдөө аж ахуйд ажиллаж буй ажилчин гэрийнхээ ажилд зориулах цагтай c_l , ажиллах цагтай l^s , үйлдвэрлэлд анхлан хэдий хэмжээний цаг E оруулахаа шийддэг. Зах зээл дээр олон тооны ажилчин z^w байгаа гэж үзнэ.

$Max_{c_l, y} u(c_l, y, z^w)$ ханамжийн функцийг орлого $y = w l^s$ ба цагийн $c_l + l^s = E$ хязгаарлалттайгаар хамгийн их байлгах юм. Орлого ба цагийн хязгаарлалтыг нэгтгэвэл $w c_l + y = w E$ болж, орлогын бүрэн хязгаарлалтыг харуулна.

Ажилчны гэрийнхээ ажилд зориулах цагийн эрэлт нь:

- $c_l = c_l(w, E, z^w)$ болно. Яагаад гэвэл, уг ажилчин ч гэсэн хэрэглэгч байх тул нэг талаас хэрэглэгч, нөгөө талаас ажилчин гэсэн утгаар шийдвэр гаргаж байгаа болохоор хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн онцлог энд илэрч байна.

Тиймээс цаашид хөдөө аж ахуйн өрхүүдийн үйл хөдлөлийг шинжлэхдээ хэрэглэгч-хөдөө аж ахуйд ажиллагч хоёрыг хамтатган нэг субъект болгон авч

үзэх болно. Энэ нь микроэкономиксийн загварт хэрэглэгчийн үйл хөдлөлийг таамагладгаас арай онцлог гэдгийг харуулж байна.

Зах зээл дээр хэрэглэгч-хөдөө аж ахуйд ажиллагч z^{cw} байна гэж үзээд түүний ханамжийн функцийг хамгийн их байлгах асуудлыг шийдье.

$Max_{c_a, c_m, c_l} u(c_a, c_m, c_l; z^{cw})$ ханамжийн функцийг $p_a c_a + p_m c_m = w l^s = y$ гэсэн төсвийн хязгаарлалт, $c_l + l^s = E$ цагийн хязгаарлалттайгаар хамгийн их болгох юм. Энэхүү хоёр хязгаарлалтыг нэгтгэвэл $p_a c_a + p_m c_m + w c_l = w E$ болно.

Тэгэхээр хэрэглэгч-хөдөө аж ахуйд ажиллагчийн эрэлтийн функц нь:

- $c_i = c_i(p_a, p_m, w, E; z^{cw})$, $i = a, m, l$.

Хөдөө аж ахуйд үйл ажиллагаа эрхэлж буй өрхүүд *хэрэглээ, үйлдвэрлэл, гүйцэтгэх ажлынхаа хуваарийг* нэгэн зэрэг шийдэх хэрэгтэй болдог. “Гүйцэтгэх ажлын хуваарь” гэсэн ойлголт нь үндсэндээ өрхийн үйлдвэрлэлийн хэмжээ, цаг агаарын нөхцөл байдал, ажлын зохион байгуулалт гэх зэргээс хамаараад, аль эсвэл өмнө дурдсаны дагуу “...хэрвээ гэрт байгаа ажиллагсдын тоо хангалттай гэж үзвэл орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн үйл ажиллагаанд оролцож болно; харин үйлдвэрлэл хэрэглээнээсээ бага хийгээд ажиллагсдын тоо хүрэлцэхгүй гэж үзвэл хөдөө аж ахуйн өрхүүд шинээр бараа худалдан авагч, мөн шинээр ажил хайгч болно” гэсэн санааг илэрхийлнэ. Үндсэндээ хөдөлмөрийн зах зээлийн үйл ажиллагаанд оролцох хэсэг гэж үзэж болно. Мөн түүнчлэн хувийн ба өрхийн хэрэглээ, хөдөлмөрийн үнээс гүйцэтгэх ажлын хэмжээ ихээхэн хамаарна.

Ингээд хөдөө аж ахуйн өрхийн ханамжийн функцийг загвараар илэрхийлбэл:

$$Max_{q_a, x, l, c_a, c_m, c_l} u(c_a, c_m, c_l; z^h) \text{ гэсэн функцийг}^6$$

$g(q_a, x, l, z^q) = 0$ гэсэн үйлдвэрлэлийн функц,

$p_x x + p_m c_m = p_a (q_a - c_a) + w(l^s - l)$ гэсэн бэлэн мөнгө,

⁶ $u(c_a, c_m, c_l; z^h)$ - ханамжийн функц, энд c_a - хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хэрэглээ, c_m - аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэрэглээ, c_l - гэрийнхээ ажилд зориулах цаг, z^h - өрхийн шинж чанар, q_a - нэг төрлийн бүтээгдэхүүн буюу а-г үйлдвэрлэнэ, x - хоёр төрлийн хүчин зүйл ашиглахын нэг нь, l - хөдөлмөр

$c_l + l^s = E$ гэсэн цаг хугацааны
хязгаарлалттайгаар
хамгийн их байлгах юм.

Хэрвээ хөдөө аж ахуйн өрхийн үйлдвэрлэлийн ашиг $\pi = p_a q_a - p_x x - w l$ гэж хязгаарлагдаж байгаа бол загварын сүүлийн хоёр хязгаарлалтыг нэгтгээд нэг тэгшитгэлд оруулж болно.

Энэ тэгшитгэл нь $p_a c_a + p_m c_m + w c_l = \pi + w E = y^*$ хэлбэртэй болно.

Хөдөө аж ахуйн өрхийн үйлдвэрлэлийг шинжлэхэд гэртээ зориулан ажиллах цагийн тухай ойлголтын утга маш чухал. Яагаад гэвэл, энэ цаг шууд өрхийн үйлдвэрлэл юм уу хөдөлмөрийн зах зээлийн үйл ажиллагаанд хамаарахгүй. Энэ цагийг ихэнхдээ хүүхэд болон хөгшчүүлээ асрах, хоол ундаа бэлтгэх, мод түлээгээ бэлтгэх, айл хөршийнхөнтэйгээ уулзах, баяр тэмдэглэх, уулзалт, үдэшлэгт явах зэрэг айл өрх, гэр бүл, нийгмийн харилцаанд оролцох цаг гэж үзнэ. Амралтын цаг ч гэсэн орох боловч одоогийн байдлаар хөдөө орон нутагт дэд бүтэц сайн хөгжөөгүй, нийгмийн бараагаар төдийлөн сайн хангагдаагүй болохоор, мөн амьжиргааны наад захын асуудал илүү чухал байгаа тул хөдөө аж ахуйн өрхүүдэд амралтын гэх цаг хомсхон байдаг. Ерөнхийдөө гэртээ зориулах цагийг ихэсгэнэ гэвэл бараа бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэх учиртай, барааны эрэлтийг нэмэгдүүлэхэд орлого илүү их байх шаардлагатай болохоор хөдөө аж ахуйн өрхүүд илүү ажиллах л хэрэгтэй болно. Гэхдээ энэ асуудал хөдөө аж ахуйн хөдөлмөр, тэр тусмаа мал аж ахуй, газар тариалангийн хувьд ялгаатай. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хувьд шинэ шинэ стандартууд бий болох нь юу юунаас чухал. Өрхүүд бэлэн мөнгөний хомсдолтой учраас тэдний орлогыг нэмэгдүүлэх нэг эх сурвалж нь зах зээл дээр жижиг хэмжээгээр савласан бүтээгдэхүүнийг борлуулах сав, баглаа боодлын жижиг цехийг ч гэсэн өрхийн үйлдвэрлэлтэй зэрэгцүүлэн хөгжүүлж болох юм.

Түүнчлэн хөдөө аж ахуйн өрхийн үйл хөдлөлийг шинжлэхэд өрхөд хэн илүү шийдвэр гаргадаг вэ, тэд орлогоо ямар хугацаанд олж байдаг вэ, олсон орлогоо өөрсдийн хэрэглээ болон дараагийн үйлдвэрлэлд хэрхэн хуваарилдаг вэ гэх зэрэг асуултыг судлах нь зайлшгүй. Үнэндээ хөдөө аж ахуйн өрхүүд бэлтгэн нийлүүлж буй бүтээгдэхүүнийхээ хувьд зах зээл дээр цэвэр худалдаалагчид, харин аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүнийг хэрэглэхийнхээ хувьд цэвэр худалдан авагчид байдаг. Хөдөө аж ахуйд хөдөлмөр эрхлэхдээ наймааны шинж чанартай бараа бүтээгдэхүүнийг чанарын стандартын дагуу үйлдвэрлэх нь гэртээ зориулах ажлын цагийн үр ашигтай хуваарилалтанд чухал хувь нэмэр оруулна. Жишээлбэл, бид жилийн дөрвөн улирлаар ээлжлэн солигдох байгалийн өвс ургамал (хөмүүл, таана, гоёо, хунчир гэх мэт), ан

амьтан (тарвага, туулай гэх мэт), жимс жимсгэнэ (бөөрөлзгөнө, хад гэх мэт), таван хошуу малын бүтээгдэхүүнийг (ингэний хоормог, цагаан идээ гэх мэт) төвлөрсөн газрын хэрэглээнд жижиг хэмжээгээр савлан байнга худалдаалбал малчин өрхүүдийн орлого тасралтгүй нэмэгдэх боломж бүрдэнэ гэж үзэж байна. Хамгийн гол нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл тодорхой цаг хугацаатай болохоор тасралтгүй үйл ажиллагааг хангахад орчин үеийн техник, технологийн ололтыг, жишээлбэл, хадгалалтын горимд нийцэх хөргөх төхөөрөмжийн ашиглалтыг нэвтрүүлмээр байна.

Төгс ба төгс бус өрсөлдөөнт зах зээл дээрх хөдөө аж ахуйн өрхүүдийн үйл хөдлөл

Хэрвээ төгс өрсөлдөөнт зах зээл байвал өрхүүдийн хувьд бүх барааны үнэ экзоген хувьсагч болж, бүх бараа болон хүчин зүйлүүд зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээр тодорхойлогдон ямар нэгэн трансакцийн зардал байхгүй. Энэ тохиолдолд өрхийн үйлдвэрлэл, хэрэглээ, хөдөлмөрөө зах зээлд нийлүүлэх талаарх шийдвэрүүд бүгд үнээр тодорхойлогдох болно. Өөрөөр хэлбэл, уг үнэ өрхийн эзэмшиж буй хүчин зүйлс болон худалдан авах барааны алдагдсан боломжийн зардлыг тодорхойлно. Нэгэнт бүх зах зээл ажиллаж байна гэж үзвэл өрхүүд өөрсдийн бүтээгдэхүүнийг хэрэглэх үү, аль эсвэл тэдэнд хэрэгцээтэй байгаа зүйлээ худалдах уу гэдэгт ялгаа байхгүй. Мөн түүнчлэн хүчин зүйлийн хувьд авч үзвэл, өрхүүд өөрсдийн хөдөлмөрийг ашиглах уу, аль эсвэл тэдэнд хэрэгцээтэй байгаа хөдөлмөрийг хөлслөн авах уу гэдэгт ялгаа байхгүй. Ийм нөхцөлд хэрэглээ, үйлдвэрлэл, хөдөлмөрийн нийлүүлэлт байнга тасралтгүй хангагдаж, үүнийг даган өрхүүд үйл хөдлөлөө тодорхойлох болно. Гэхдээ ийм төгс зах зээл бол салангид авч үзэхэд хүрэлцээтэй нөхцөл болохоос биш, зайлшгүй нөхцөл биш. Бүх зах зээл ажиллаад үнийг экзоген хэлбэрээр тодорхойллоо ч худалдах ба худалдан авах үнэ ялгаатай байж болох юм.

Төгс өрсөлдөөнт зах зээлд эхлээд үйлдвэрлэлийн хэмжээг тодорхойлоод дараа нь хэрэглээний ба хөдөлмөрөө нийлүүлэх асуудлыг шийдье.

1. Үйлдвэрлэлийн асуудал.

$Max_{q_a, x, l} \pi = p_a q_a - p_x x - w l$ ашгийн функцийг $g(q_a, x, l, z^q) = 0$ гэсэн

үйлдвэрлэлийн функцийн хязгаарлалттайгаар хамгийн их байлгах асуудлыг шийдэх болно.

- нийлүүлэлтийн функц: $q_a = q(p_a, p_x, w, z^q)$,
- хүчин зүйлийн эрэлтийн функц: $x = x(p_a, p_x, w, z^q)$,
 $l = l(p_a, p_x, w, z^q)$,

- максимум ашиг: $\pi = \pi(p_a, p_x, w, z^q)$ байна.

2. Хэрэглээ ба хөдөлмөрийн асуудал

$\text{Max } u = (c_a, c_m, c_l, z^h)$ гэсэн функцийг $p_x x + p_m c_m + w c_l = \pi^* + wE$ гэсэн

орлогын хязгаарлалт, $c_l + l^s = E$ гэсэн цаг хугацааны хязгаарлалттайгаар хамгийн их байлгах юм.

- Эрэлтийн функц нь: $c_i = c_i(p_a, p_m, w, y^*, z^h)$, $i = a, m, l$.
- энд $y^* = p_a q_a - p_x x - w l + wE$

Хэрэглээ ба үйлдвэрлэлийг холбох гол ойлголт бол π^* юм. Яагаад гэвэл, бараа бүтээгдэхүүний үнэ p_a ба хөдөлмөрийн үнэ w хэрэглээ ба үйлдвэрлэлийн талаарх шийдвэрт тусгагдсан байгаа. Бодлогын шинжилгээний гол асуудал бол эдгээр үнэ тухайн нэг өрхийн хувьд зарлага уу, аль эсвэл орлого болох уу гэдэг нь чухал. Тиймээс өрх хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг цэвэр худалдан авагч байна уу, аль эсвэл цэвэр худалдаалагч байна уу гэдэг нь бодлогод маш чухал нөлөөтэй.

Хөдөө аж ахуйн зарим өрх өөрсдийн хэрэгцээгээ зөв зохицуулснаар зах зээлд нэмэгдэл бүтээгдэхүүн борлуулах боломжтой байдаг. Тиймээс ийм өрхүүд нийлүүлж буй бүтээгдэхүүнийхээ тухайд зах зээлийн илүүдэлтэй байна гэсэн үг.

Зах зээлийн илүүдэл $= q_a - c_a > 0$ бол цэвэр худалдаалагч, харин зах зээлийн илүүдэл $= q_a - c_a < 0$ бол цэвэр худалдан авагч байна.

Хөдөлмөрийн нийлүүлэлт $= l^s = E - c_l$

Хөдөлмөрийн тэнцэл $= l - l^s > 0$ бол хөдөлмөрийг хөлсөлнө. Харин хөдөлмөрийн тэнцэл $= l - l^s < 0$ бол хөдөлмөрөө хөлслүүлэх болно.

Шинжилгээний үр дүнг тодорхойлохын тулд хөдөө аж ахуйн өрхүүдийг ангилж үзэх хэрэгтэй болно. Жишээлбэл, тариалан өрхүүдийг өөрийн эзэмшлийн газартай ба газаргүй гэж ангилж болох юм. Харин малчин өрхүүдийн хувьд малын тооны интервалаар ангилан хувааж болно. Үүний дараа ангилалд тус бүрд байгаа өрхүүдийн хүнсний бүтээгдэхүүний мэдрэмжийг тодорхойлно. Өөрөөр хэлбэл, дээрх ангиллын дагуу үнэ өөрчлөгдөхөд өрхүүд ямар үйл хөдлөлтэй байхыг судлах юм.

Хүнсний бүтээгдэхүүний эрэлтээс үнээр уламжлал тооцоход уг барааны орлуулалт ба орлогын нөлөө ямар байгааг тодорхойлно.

$$\frac{\partial c_a}{\partial p_a} = \frac{\partial c_a}{\partial p_a} \Big|_{y^*=const} + \frac{\partial c_a}{\partial y^*} \frac{\partial y^*}{\partial p_a} \Big|_{y^*=const} + q_a \frac{\partial c_a}{\partial y^*}$$

Слутцкийн тэгшитгэлийг ашиглан дээрх уламжлал тооцсон тэгшитгэлийн баруун гар талыг орлуулалт ба орлогын нөлөө ямар байгааг шинжилж болно.

$$\frac{\partial c_a}{\partial p_a} = \frac{\partial c_a}{\partial p_a} \Big|_{u=const} - c_a \frac{\partial c_a}{\partial y^*} + q_a \frac{\partial c_a}{\partial y^*} = \frac{\partial c_a}{\partial p_a} \Big|_{u=const} + (q_a - c_a) \frac{\partial c_a}{\partial y^*}$$

Тэгшитгэлийн эхний утга бол орлуулалтын нөлөөг харуулж байгаа бөгөөд орлуулалтын нөлөө сөрөг байна. Яагаад гэвэл $\frac{\partial c_a}{\partial y^*}$ эерэг байгаа болохоор ийм бараа хэвийн бараа байна. Цаашилбал, тэгшитгэлийн хоёр дахь утга өрхийг барааны хувьд цэвэр худалдаалагч уу $q_a - c_a > 0$, аль эсвэл цэвэр худалдан авагч уу $q_a - c_a < 0$ гэдгийг харуулах юм. Магадгүй мал цөөхөнтэй юм уу, өөрийн эзэмшлийн газаргүй тариаланчдын хувьд цэвэр худалдан авагч гэсэн үр дүн гарч болох юм. Өөрөөр хэлбэл, $\frac{\partial c_a}{\partial p_a} < 0$ гэсэн үр дүн гарна гэсэн үг. Харин энэхүү уламжлал эерэг утгатай гарвал олон малтай, эзэмшлийн газар тариалангийн талбай томтой фермерүүдийн хувьд цэвэр худалдагч гэсэн үр дүн ажиглагдаж болно.

Хөдөө аж ахуйн өрхүүдийн үйл хөдлөлийг ийнхүү барааны үнийн мэдрэмжтэй холбоотойгоор тайлбарлаж болохоос гадна цалин хөлстэй уялдуулан гэрийн ажилдаа зориулах цагийн эрэлтийн мэдрэмжийг тодорхойлж болох юм.

$$\frac{\partial c_l}{\partial w} = \frac{\partial c_l}{\partial w} \Big|_{u=const} + (E - c_l - l) \frac{\partial c_l}{\partial y^*} = \frac{\partial c_l}{\partial w} \Big|_{u=const} - (l - l^s) \frac{\partial c_l}{\partial y^*}$$

Тэгшитгэлийн эхний утга мөн сөрөг гарч байна. Харин хоёр дахь утга $(l - l^s)$ өрхийн хөдөлмөрийн тэнцлийг харуулах бөгөөд хөдөлмөр хөлсөлж, ажиллуулж буй өрхийн хувьд эерэг, харин хөдөлмөрөө хөлсөлж ажиллаж байгаа өрхийн хувьд сөрөг утгатай байж болно. Өөрөөр хэлбэл, хөдөлмөр хөлсөлж байгаа өрхийн хувьд мэдрэмжийн утга сөрөг, яагаад гэвэл, цалин бол зардал юм. Хэрвээ цалинг өсгөвөл тэдний орлого буурах учраас гэрийн ажилдаа зориулах цаг багасах болно. Харин малын тоо толгой бага юм уу өөрийн эзэмшлийн газар үгүй өрхүүдийн хувьд хөдөлмөрөө хөлслүүлэх учраас мэдрэмжийн утга ямар ч байж болно. Яагаад гэвэл, цалин бол тэд нарын хувьд орлого юм. Орлогын түвшин бага байхад чөлөөт цагийн орлогын мэдрэмж өндөр болж, чөлөөт цаг бараг гарахгүй. Ийм тохиолдолд цалин

өсөхийн хэрээр өрхүүдийн цагийн ачаалал багасч, чөлөөт цагийн хэрэглээ нэмэгдэн өрхүүд илүү наад захын хэрэгцээгээ хангах боломжийг өөрсдөө бүрдүүлэх болно.

Улс орнуудын хөгжлийн туршлагыг ажиглахад ядуу өрхүүд ч гэсэн хүнсний бүтээгдэхүүний хувьд зах зээлийн илүүдэлтэй байдаг. Хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөхөд ийм зах зээлийн илүүдэл багасч болно. Тиймээс бодлого боловсруулагчид хөдөө аж ахуйн өрхүүдийн хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн илүүдлийг анхаарч, бодлого хөтөлбөрт тусгах нь чухал. Гэхдээ энд бас сөрөг утга ажиглагдсан тохиолдол байгааг санах нь чухал гэж бодож байна. Жишээлбэл, Энэтхэг болон Египетэд тариачдын үйлдвэрлэж буй үр тарианд албадлага хэрэглэн төвлөрүүлснээр эдгээр улсын жижиг тосгонд өрхүүдийн хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн илүүдэл сөрөг утгатай гарах үзэгдэл ажиглагдаж байсан. (Bardhan 1970, de Janvry and Kumar 1981)

Хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн илүүдлийг $ms_a = q_a - c_a > 0$ гэж тодорхойлбол үнээс хамаарах өөрчлөлт нь дараах байдалтай:

$$\frac{\partial ms_a}{\partial p_a} = \frac{\partial q_a}{\partial p_a} \frac{\partial c_a}{\partial p_a} \Big|_{u=const} - ms_a \frac{\partial c_a}{\partial y^*}.$$

Үйлдвэрлэл ба хэрэглээ мэдээж эерэг утгатай байна. Харин үнэхээр ядуу өрхүүдийн хувьд хүнсний хэрэглээнд орлогын мэдрэмж өндөр байвал дээрх илэрхийлсэн утга сөрөг гарна. Тиймээс эргээд нийлүүлэлтийн мэдрэмжийг бууруулах, хүнсний бүтээгдэхүүн болон бусад бүтээгдэхүүний хооронд бага орлуулалт хийлгэхээр албан хүч хэрэглэх болно.

Ийнхүү хөдөө аж ахуйн өрхүүдийн үйл хөдлөлийг төгс өрсөлдөөнтэй зах зээлийн орчинд хэрхэн судлахыг харууллаа.

Төгс бус өрсөлдөөнт зах зээл дээрх хөдөө аж ахуйн өрхүүдийн үйл хөдлөлийг шинжлэх нь бодлого боловсруулагчдад нэн чухал.

Хөдөө аж ахуйн зах зээл яагаад гажуудалтай байна вэ гэсэн асуултын шалтгаан, үр дагаврыг судална гэсэн үг. Хөдөө аж ахуйн өрхүүд зах зээлээсээ хол оршиж байгаа нь хамгийн эхний шалтгаан юм. Хөгжиж буй орнуудын хотоос алслагдах тусам дэд бүтэц сул хөгжсөн байдаг. Өрхүүд бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэхэд транзакцийн зардал их гарах болно. Үүний зэрэгцээ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний маркетингийн сүлжээний хөгжил доогуур. Орон нутгийн зах зээлд хүн амын нягтаршил сийрэг бол монополизм хүч өндөр байна. Мэдээлэл гүйцэд бус учраас мэдээлэл олж авах зардал өндөр,

мэдээлэлээ ашиглах боломж сул. Ямар ч тохиолдолд зөв боловсруулалт хийж, ашиглахад хугацаа их шаардлагатай.

Дараагийн шалтгаан бол хөдөө аж ахуйн өрхүүд өөрсдийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээ зах зээлд хямд борлуулан хөдөлмөрөө бага үнэтэйгээр нийлүүлээд, харин зах зээлээс илүү өндөр үнэтэй бараа болон хүчин зүйлийг худалдан авах болдог явдал юм.

Өөр нэг шалтгаан гэвэл хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэр төрөл цөөн болохоор хөдөө орон нутгийн хэрэглээний үнийн сагсыг газар нутгийн онцлогтой уялдуулан бүрдүүлнэ гэвэл хувийн жин өндөртэй, цөөхөн бүтээгдэхүүнээс бүтэх болно. Хэрвээ субъектив байдлаар авч үзэн хөдөө орон нутагт зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээр үнэ тогтоно гэж үзэх юм бол эдгээр цөөхөн бараанаас хөдөө аж ахуйн өрхүүд сонголт хийн өөрсдийн сайн сайхан байдлаа хангаж болох юм. Гэсэн хэдий ч эдгээр цөөхөн барааны үнэ тухайн орон нутгийн "хэрэглээний үнийн сагсныхаа" хувьд буурч болно. Цөөхөн төрлийн бараа борлуулж байгаа ч үнэ өндөртэй, зах зээлийн эрэлт их байхаар өөрчлөлт хийж болно. Энд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний маркетингийн асуудал чухал нөлөө үзүүлнэ.

Бас нэг шалтгаан нь хөдөө орон нутагт санхүүгийн зах зээл маш сул хөгжиж байгаа явдал юм. Үүний нэг жишээ бол хөдөөгийн өрхүүдэд эргэлтийн хөрөнгийн зээлийн эрэлт их байдаг. Мөн түүнчлэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зээлийн хугацаа ч нөлөөлж болно. Хөдөө аж ахуйн өрхүүдийн орлого, зарлагын талаар сонирхоод үзэхэд улирлын шинж чанартай орлого ба зарлагын хэлбэлзэл өндөр учраас сүү, цагаан идээгээ боловсруулах юм уу, ноос, ноолуураа хяргах, хадлан тэжээл бэлтгээд борлуулах, ургацаа хураах үед орлого олох боломжтой. Эдгээр нь өрхийн орлогын гол эх үүсвэр болно. Үүний зэрэгцээ цаг зуурын хэрэглээндээ зориулж, малаа нядлан борлуулснаар орлогоо залгуулах боломжтой. Хөдөө сумдад бусад зах зээлүүд, тэр дотроос хөрөнгийн зах зээл, газрын зах зээл сайн хөгжөөгүй болохоор өрхийн хэрэглээний хүрээ хязгаарлагдмал байх талтай. Ерөнхийдөө хөдөө аж ахуйн өрхүүд ядуурах эмзэг байдалд өртөх магадлал өндөр. Өөрөөр хэлбэл, тэдний хэрэглээ буурах магадлал их. Байгаль, цаг уурын байдлаас хараат болохоор бэлчээр хомсдох, малын тоо гэнэт буурах, гар дээрх бэлэн мөнгө бага байх гээд эрсдэл ихтэй. Алдагдсан боломжийн өртөг өндөртэй. Хэдийгээр бичил санхүүгийн үйл ажиллагаа орон нутагт өргөжиж байгаа боловч аймаг, сумдад харилцан адилгүй байна. Тиймээс үйлдвэрлэлийн хүчин зүйлс, даатгал, зээл гээд олон асуудлын зөвшилцөл, гэрээ хөгжөөгүй. Зөвшилцөл, гэрээ хөгжөөгүй болохоор өмчийн эрхийн асуудал ч гажуудалтай. Гэсэн ч хөдөө аж ахуйн өрхүүдийн шинжилгээ хөгжлийн бодлогод зайлшгүй чухал.

Манай улсын хөдөө аж ахуйн өрхүүдийн үйл хөдлөлд зах зээлийн бус үйл ажиллагаа нилээд нөлөөтэй байдаг. Үүний нэг жишээ бол малчин өрхүүдийн бэлтгэж буй малын түүхий эд. Малын түүхий эдийг худалдах, худалдан авах орон нутгийн түүхий эд бэлтгэлийн төв байна. Гэхдээ өнөөгийн туршлагаас харахад ихэнхдээ жижиг бөөний дамжлага хэлбэртэйгээр оршин тогтнож, мал махны ченжүүдийн үйл ажиллагаагаар дамжин зохицуулагдаж, аль эсвэл аймагт төдийгүй бүс нутагтаа монополь болсон түүхий эд-бэлтгэлийн төв байна. Энд ариун цэвэр, эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангаж, хэрэглэгчдийн эрх ашигт нийцүүлэн жижиг хэмжээгээр юм уу бөөнөөр савласан малын гаралтай бүтээгдэхүүнийг зах зээл дээр хүлээн авч, борлуулах үйл ажиллагааг хангах маркетингийн сүлжээ гарцаагүй шаардагдаж байна. Хэрвээ хөдөө орон нутагт бүх зах зээлүүд ажиллаж байвал хөдөө аж ахуйн өрхийн үйлдвэрлэл ба хэрэглээний шийдвэр гаргалтын уялдаа холбоог тэдгээрийн үйлдвэрлэлээсээ олох орлогын түвшингээр тодорхойлж болох юм. Харин хөдөө орон нутагт бүх зах зээлүүд ажиллахгүй байгаа болохоор хөдөө аж ахуйн өрхийн үйлдвэрлэл ба хэрэглээний шийдвэр гаргалтын хооронд шууд холбоо байна гэж үзэж болно. Аль ч тохиолдолд хөдөө аж ахуйн өрхүүдэд чиглэсэн бодлого үйлдвэрлэсэн (ашигласан) ба хэрэглэсэн (худалдсан) барааны үнэд нөлөөлдөг. Тийм болохоор хөдөө аж ахуйн өрхүүдэд баялагтай болох гэдэг юм уу хөдөө аж ахуйн өрхүүд үйлдвэрлэл эрхлэх гэдэг бол яах аргагүй тусгайлан судлах зүйлтэй, өөрийн гэсэн онцлог загвараар илэрхийлэгдэх, хөгжлийн бодлогод чухал нөлөө үзүүлэх Монголын малчин өрхүүдийн зан төлөвийг илэрхийлэх загвар, үнэлгээ, үр дүнгийг нь зайлшгүй боловсруулах хэрэгтэй байна. Энэ чиглэлийг шинэ сонгодог онолын загвараар баяжуулан хөгжүүлбэл хөдөө аж ахуйн өрхүүдийг газар тариалан эрхэлж байгаа өрхүүдээс, мөн түүнчлэн хөдөө орон нутагт амьдарч буй өөр бусад өрхүүдээс ялгаатайгаар авч үзэх бодлого бий болно. Хөдөө аж ахуйн өрхүүд дотор ч малын тоогоороо ялгаатай, хүмүүсийн чадавхиар ялгаатай, хэрэглээний зан заншлыг өвлөж авсан арга барилаараа ялгаатай өрхүүд байгаа билээ. Өөрөөр хэлбэл, зарим хөдөө аж ахуйн өрхүүд зах зээлийн өрсөлдөөнд тогтвортой байр сууриа олж чадаж байхад зарим нь үгүй. Иргэний нийгэм, бизнесийн нийгмийн хариуцлага гэж ярьж байгаа үед хамтаар ажиллах сэтгэлгээ хүчтэй төлөвшиж байгаа аймаг, орон нутаг, хот айлууд байхад зарим аймаг, сумдад ийм хандлага сул хөгжиж байхыг үгүйсгэхгүй.

Тэгэхээр хөдөө аж ахуйн өрхүүдийн загварт ялгаатай өрхүүдийг авч үзэж болно. Яагаад гэвэл хөдөө аж ахуйн өрхүүд өрсөлдөөнтэй орчинд орж болно. Үгүй бол хөдөө аж ахуйн өрхүүд бусад өрхүүдээс ялгагдахгүй байж болно. Нөгөө талаар ингэж ялгаж авч үзэх гол шалтгаан бол өрхүүдийн трансакцийн зардал ялгаатай байгаа явдал. Мөн өөрсдийнхөө хөрөнгийг хянаж байгаа байдал ялгаатай гэж үзэж байна. Өөр өнцгөөс ч бас харж болох юм. Юу гэвэл, улс орнуудын түүхийг эргэн харахад тариачин өрхүүдийн амьжиргаа улс төрийн хувьд их нухацтай асуудал байсан. Англид газар тариалангийн

үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор "Үр тарианы тухай" хуулийг баталж, импортын тарифыг өндөр тогтоож байжээ. Япон, Францад хөдөө аж ахуйн худалдааны бодлогыг хэрэгжүүлж байсан. Ази, Африкийн ихэнх оронд газрын түрээсийн тогтолцоо, газрын шинэтгэлийн хөтөлбөрийг туршиж, хэрэгжүүлэхээр хүчилж байжээ. Манай улсад зах зээлийн шилжилт нэгдлүүдийг хувьчилснаар эхэлсэн түүхтэй.

Төгсгөлийн оронд...

Тиймээс цаашид хөдөө аж ахуйн аливаа хөдөлмөрийг үнэ цэнэтэй болгож, трансакцийн зардлыг бууруулан нүүдлийн соёл иргэншилд нийцэх зах зээлийн харилцааг бий болгохын тулд хөдөө аж ахуйн өрхүүдийн үйл хөдлөлийг нарийвчлан шинжилж, төгс бус зах зээлийн хязгаарлалттайгаар эконометрик үнэлгээ хийн турших нь зайлшгүй чухал гэж үзэж байна. Тиймээс юуны түрүүнд хөдөө аж ахуйн өрхүүдийн орлого, зарлагыг орлогын ялгаатай бүлгүүдээр буюу квантиллээр ангилсан мэдээлэл байх шаардлагатай. Мөн түүнчлэн газар тариалан эрхэлдэг өрхүүдийн хувьд ашиглаж буй газрын хэмжээгээр ангилж авч үзэх нь чухал байна. Ялгаатай газраас ямар ургацыг, хэдий хэмжээгээр хурааж байгаа мэдээллийг цуглуулах нь дүн шинжилгээнд үнэхээр ач холбогдолтой юм. Мэдээж ийм төрлийн тоо мэдээлэл, баримтыг цуглуулахад хугацаа их шаардагдахын зэрэгцээ ядаж эхний ээлжинд түүвэр судалгаа хийх хэрэгтэй болно.

Ашигласан материал:

Alain de Janvry, and Praduman Kumar. 1981. "The Transmission of Cost Inflation in Agriculture with Subsistence Production: A Case Study in Northern India", *Journal of Agricultural Economics* 36: 1-14

A.V.Chayanov, "Report of the Congress of Agronomists advising the public" (1911), "On the problem of training agricultural officers" (1914), "Fundamental ideas and working methods in Social Agronomy", (1918)

Bardhan, Kalpana. 1970. "Price and output Response under Rationing: The Role of Sectional Study of Some North Indian Villages." *American Journal of Agricultural Economics* 52: 51-61

Barnum Howard, Lyn Squire. 1979. *A Model of an Agricultural Household: Theory and Evidence*. Occasional Paper no.27, Washington, D.C.: World Bank
Becker, Gary. 1965. "A Theory of the Allocation of Time". *Economic Journal* 75: 493-517

Elizabeth Sadoulet, Alain de Janvry, 1995. *Quantitative Development Policy Analysis*. pp 140-160. Johns Hopkins University Press. Baltimore and London

Harrison, Mark. 1975. "Chayanov and the Economics of the Russian peasantry".
Journal of Peasant Studies 2: 389-417

Singh, Inderjit, Lyn Squire and John Strauss eds. 1986. Agricultural Household
Models. Baltimore Johns Hopkins University Press

World Development Report 2007: Building Institutions for Markets. pp 30-53,
World Bank

World Human Development Report 2007, pp...

Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаа 2000, хуудас 16-22

Монголын хүний хөгжлийн илтгэл, 2003, хуудас 22-28

Х.Цэвэлмаа, Малчин өрхүүдийн бүлэг хоршооны зээл болон тоног
төхөөрөмжийн зээлийн үнэлгээ (Оролцооны аргын судалгаа), 2006, Дэлхийн
банк ба Өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр,
Тогтвортой амьжиргаа төсөл.